

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

CAUSES AND CONDITIONS OF SEXUAL ABUSE AGAINST MINORS

Б.Даваажав

*Дотоод хэргийн их сургуулийн магистрант,
цагдаагийн ахмад*

Товч агуулга: Хүүхдийн эрхийн зөрчлийн ноцтой хэлбэр нь хүчирхийлэл, тэр дундаа “бэлгийн хүчирхийлэл” юм. 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн “Хүүхдийн эрхийн тухай” конвенцод арван найман насанд хүрээгүй бүх хүнийг “хүүхэд” гэж тодорхойлсон бол, Монгол Улсын эрүүгийн хууль, тогтоомжид 14 хүртэлх насны хүүхдийг “бага насны хүүхэд” гэж ойлгохоор хуульчилсан. Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангид “хүчиндэх” гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд тооцож, арван хоёр жилээс хорин таван жил, цаашлаад бүх насаар хорих ял шийтгэхээр заасан. Монгол Улсад бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн гаралт жил ирэх тусам өсөж, үүнээс шалтгаалан нийгэм дэх айдас, бухимдал нэмэгдэж байгаа боловч нөгөөтээгүүр хууль сахиулах байгууллагаас хэрэгжүүлж буй цогц үйл ажиллагааны чанар, үр дүнд нуугдмал гэмт хэргийн түвшин өндөрт тооцогдох энэхүү гэмт хэргийн илрүүлэлт өсөж байгаа эерэг үзүүлэлт харагдаж байна. Энэхүү өгүүлэлд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй нийгэм, улс төр, эдийн засгийн болон бусад хүчин зүйлсийг судалсан бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогыг тодорхойлохдоо эдгээр хүчин зүйлийг мөн харгалзан үзэх нь зүйтэй.

Abstract: A serious form of violation of children's rights is violence, including "sexual violence." While the Convention on the Rights of the Child, adopted on November 20, 1989 and entered into force on September 2, 1990, defines a "child" as any person under the age of eighteen, Mongolia's criminal legislation defines a child under the age of 14 as a "minor." The special section of the Criminal Code in force in Mongolia stipulates that the crime of "rape" committed against a minor is considered an aggravated element of the crime of rape and is punishable by imprisonment for a term of twelve to twenty-five years, or even life. The incidence of child rape in Mongolia is increasing year by year, which has led to increased fear and anxiety in society, but on the other hand, the quality and effectiveness of comprehensive activities implemented by law enforcement agencies have shown a positive trend, with an increase in the detection of this crime, which is considered a high level of hidden crime. This article examines the social, political, economic and other factors that influence the commission of child rape, and these factors should also be taken into account when determining the penal policy to combat this type of crime.

Түлхүүр үгс: Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг, бага насны хүүхэд, насанд хүрээгүй хүн, бэлгийн эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал.

Keywords: Sexual violence, rape, young children, minors, sexual freedom, sexual inviolability.

Удиртгал

Бэлгийн хүчирхийлэл, тэр дундаа бага насны хүүхдийн эсрэг үйлдэгддэг бэлгийн хүчирхийлэл нь нийгмийг хор аюул өндөр бөгөөд бодлогын түвшинд анхаарал хандуулах шаардлагатай, нийгэм дэх ноцтой асуудлын нэг юм. Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг нь нийгэм, улс төр, эдийн засгийн олон хүчин зүйлтэй холбоотой бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогыг тодорхойлохдоо эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг зайлшгүй харгалзан үзэх нь зүйтэй. Хууль тогтоох дээд байгууллагаас Монгол Улсын Эрүүгийн хуулийг 2002, 2015 онд шинэчилсэн найруулгыг баталж, уг хуулиудад хүний эрх, эрх чөлөө, хүүхдийн эрхийг хамгаалах, ялангуяа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт үйлдлийг онц, хүнд гэмт хэрэгт тооцож, оногдуулах ялын төрөл, хэмжээг чангатгасан билээ. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчныг тодорхой бүрдүүлж, төрөөс хүүхэд хамгааллын бодлогыг тодорхойлон, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа эрчимжиж байгаа хэдий ч хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдол, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй бэлгийн хүчирхийлэл буурахгүй байна. Хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.4 дэх хэсэгт “Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” үйлдлийг хүчиндэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжид хамааруулж, “бага насны хүүхэд” гэдгийг 14 насанд хүрээгүй хүүхэд байна (Монгол Улсын Их Хурал, 2015) гэж тодорхойлсон байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсад сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2014 оноос 2024 онд хүчиндэх гэмт хэргийн улмаас нийт 2600 орчим хүүхэд хохирсон байна. Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэргийн гаралт мөн сүүлийн 10 жилийн хугацаанд буурахгүй, тогтмол өссөн байна. Хүүхэд, тэр дундаа бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн хүчиндэх гэмт хэрэг нь дан ганц хохирогчдын эрүүл мэнд, бие махбодод гэмтэл учрахаас гадна, тэдний сэтгэл зүйд ноцтой гэмтэл учруулан, тухайн хүүхдийн ирээдүй, ёс суртахууны хөгжилд сөргөөр нөлөөлдөг. 2014 онд хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг 124 бүртгэгдэж байсан 2023 онд 384 бүртгэгдсэн буюу энэ төрлийн гэмт хэргийн гаралт 67.7 хувиар өссөн байна (ГХУСАЗЗАА, 2016-2023).

Үүний зэрэгцээ, 2018 онд хүчиндэх гэмт хэрэг 2016 онтой харьцуулахад 44.1 хувиар огцом өссөн байгаа нь 2017 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуульд “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн” гэж заасантай холбоотой байна. Өөрөөр хэлбэл, дан ганц бэлгийн харьцаанд орсон, хурыцал үйлдсэнийг бус, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн, хохирогчийг оролдсон зэрэг үйлдлүүдийг хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талд хамааруулсантай холбоотойгоор бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдсэн гэж үзэж болохоор байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн тоо, мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- Гэр бүл дэх таагүй уур амьсгал, эцэг эхийн таарамжгүй харилцаа, гэр бүл салалт;
- Хүүхдэд хандуулах хараа, хяналт сул;
- Төрөөс хүүхдийг хамгаалах чиглэлээр баримталж буй бодлогын хэрэгжилт хангалтгүй;
- Архидалт;
- Эцэг эхийн зүгээс үйлдэж буй үл хайхрах хүчирхийлэл;
- Нийтийн цахим сүлжээн дэх хяналт сул;
- Гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал;
- Хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь дийлэнх тохиолдолд ахуйн хүрээнд, хохирогчтой хамаарал бүхий этгээдээс үйлдэгдсэн байх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогчтой хамаарах байдлаар нь авч үзвэл:

- Төрсөн эцэг- 2.9%,
- Хойд эцэг - 40.2%,
- Төрөл садан - 29%,
- Бусад - 27.9% хувийг тус тус эзэлж байна (форум, 2020).

Бага насны хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох чиглэлээр 2023 онд гүйцэтгэсэн судалгаагаар сошиал орчинд танилцсан хүндээ хүчиндүүлсэн тохиолдол 1.6% буюу 8 гэмт хэрэг, үл таних хүнд хүчиндүүлсэн 14.1% буюу 69 гэмт хэрэг, хамаатан садан, танилын хүндээ хүчиндүүлсэн 84.2% буюу 406 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэргийн 84.2%-ийг хохирогчийн төрсөн эцэг, ах дүү, хамаатан садны хүмүүс үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүний иргэний харьяаллыг авч үзвэл Монгол Улсын иргэн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэж ял шийтгүүлсэн 68 тохиолдлын 66 буюу 97.1 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 40 тохиолдлын 38 буюу 95 хувь нь тус тус Монгол Улсын иргэн байна.

Сүүлийн 5 жилд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 98 хувийг эрэгтэй, 2 хувийг эмэгтэй хүн үйлдсэн ба энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг насаар нь ангилбал:

- 14-18 нас 12 хувь;
- 19-30 нас 48 хувь;
- 31-50 нас 33 хувь;
- 51-74 нас 7 хувийг тус тус эзэлж байна.

Өсвөр насны хүмүүсийн болон хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт явдлын шалтгааныг криминологийн онолын үүднээс:

1.Объектив шалтгаан (нийгмийн харилцаа, эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй шалтгаан, насанд хүрээгүй хохирогчийн /виктим/ шинж;

2.Субъектив шалтгаан гэж ангилж болно.

Объектив шалтгаан: Нийгмийн хамгийн анхдагч, үндсэн нэгж гэр бүлийн байдал, нийгмийн хяналт, чөлөөт цаг зэрэг орно. Ес суртахууны үнэт зүйлсийн мэдрэмжгүй байдал, ажилгүйдэл, нийгмийн гишүүдийн дийлэнх хэсгийн ядуурлын явцын хурдацтай байдал зэрэг нь гэр бүлийн “уналт”-ыг илэрхийлж байна. Мөн гэр бүлийн маргаан зөрчилдөөн, эд хөрөнгийн ба сэтгэлийн холбоос алдагдсанаар гэр бүл салалт (албан ёсоор гэрлэлтээ батлуулсан иргэдийн тоо ихсэхэд насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг гэмт хэргийн тоо багасна), төрөлт багасах, гэр бүл нийгмээс тусгаарлагдах, гэр бүлийн нэр хүнд унах ноцтой шинж тэмдгүүд өсдөг байна. Нийгмийн хяналтын сулрал нь гэмт хэргийн гаралтад дараах хоёр чиглэлээр нөлөөлнө.

Нэгдүгээрт: гэр бүлийн ёс суртахууны дотоод хэм хэмжээ хяналтаас алдагдаж, гэр бүлийн хүрээнд нийгмийн зүгээс аливаа зорилтот хүмүүжлийн ажил явуулах, хяналт тавих боломжгүй хаагдмал болдог. Ийм гэр бүлийн хяналтгүй байдал нь дарангуйлал, дураараа аашлах, гэр бүлийн бурангуй ёс жаяг, эцэг эхийн засаглалыг бий болгох, насанд хүрээгүй гишүүний эрхийг зөрчих, тэдний эсрэг гэмт хэрэг үйлдэх, хүүхэд гэр орноосоо дайжих, гэмт хэрэгт татагдан орох явдлыг бий болгоно.

Хоёрдугаарт: хүүхэд, өсвөр үеийнхний зан байдлын харилцаанд сөргөөр нөлөөлнө. Сургуулиас гадуурх хүмүүжлийн ажлын тогтолцоо, хүүхэд өсвөр үеийнхний олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллагын задрал, боловсролын байгууллагын дутагдал энэ бүхэн нийгмийн идэвхийг сулруулж, насанд хүрээгүй хүмүүс нийгмийн хяналтаас ангид болдог. Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, хүмүүжлийн ажлын салангид байдал (сургуулийн хүмүүжил нь сургууль дээрх хүмүүжлээр хязгаарлагдах, суралцагчдын сургуулиас гадуурх зан байдал нь сурган хүмүүжүүлэгчдийн анхаарлаас ангид, ихэнх тохиолдолд багш нар сурагчийнхаа амьдрал ахуй, сонирхол, хаагуур юу хийж явдаг талаар огт мэдээлэлгүй байх) нь гэр бүл, сургуулийн хоорондын холбоо алдагдах, хүүхэд өсвөр үеийнхэн сөрөг үзэл бодолтой болоход нөлөөлнө.

Субъектив шалтгаан: Энэ төрлийн гэмт явдлын субъектив шалтгаан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гажуудалд орсон эрэлт хэрэгцээ, ашиг сонирхол, зорилго, зан суртахууны үнэт зүйлс ба эрх зүйн ухамсраар илэрдэг нийгмийн сэтгэл зүйн тодорхой шинж юм.

Нийгмийн, гэр бүлийн амьдралын зөв зан төлөвтэй хүмүүс нь нийгмийн оюун санааны баялаг шинжүүдийг өөртөө агуулж, өөрсдийн ажиллаж, амьдарч байгаа орчин тойрны хүмүүс, өөрийгөө хүндэтгэх үзлээр хүмүүжин, сайн ба муу, шударга болон шударга бус, үүрэг, хариуцлага, чин эрмэлзэл зэргийг зөв үнэлэн ялгах чадвар бүхий нинжин энэрэнгүй сэтгэлтэй байдаг.

Сэтгэцийн хувьд гаж буруу зан үйлтэй хүмүүсийн ухамсар, зан төлөвт доголдол гарч, үүрэг, хариуцлага, ичих, гэмшихийг умартаж түүний үндсэн дээр гэмт явдлын шалтгаан үүсдэг. Гэмт зан үйл нь тухайн хүний өссөн орчин, хүмүүжил, боловсролтой шууд хамааралтай бөгөөд гэмт зан үйлийн шинж төлөвшсөн хүмүүсийн судлах үзэхэд дийлэнхдээ энэхүү сэдэл нь тэднийг насанд хүрээгүй буюу оюун ухаан, бие бялдрын хөгжлийн дутуу байдалд илүү жинтэй үүсэж, хөгжсөн байдаг. Тухайлбал: сэтгэл зүйн гажуудал нь хүүхдийн эсрэг харгис хэрцгий байдлаар илрэх ба бэлгэсийн гэмт хэрэг үйлдэхэд онцгой нөлөөтэй.

Бага насны хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй үндсэн шалтгаан:

- Бага насны хүүхдийн насанд хүрээгүй байдал: Хүүхдүүдийн ухамсрын түвшин болон оюун санааны хөгжил нь насанд хүрэгчдийнхээс ялгаатай байдаг тул заримдаа гэмт хэрэг үйлдэж байгаагаа бүрэн ухамсарлаж чаддаггүй. Хүчиндэх гэмт хэрэг үйлдэх үед хүүхэд өөрөө нөхцөл байдлыг ойлгохгүй, бусдын нөлөөнд автаж үйлдэл хийж болзошгүй.

- Гэр бүлийн болон орчны нөлөө: Гэр бүлийн хүчирхийлэл, хүнд нөхцөл байдалд өссөн хүүхдүүд сэтгэл зүйн хувьд гэмтэл авч, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөөгүй үйлдэл хийх магадлал нэмэгддэг. Мөн өөрөө хүчирхийллийн золиос болж өссөн хүүхдүүд бусдыг хүчирхийлэх зан төлөвт суралцсан байх боломжтой.

- Сэтгэл зүйн болон боловсролын дутмаг байдал: Хүүхдүүдийн сэтгэл зүйг ойлгон дэмжих хөтөлбөр, сургалт бага байгаагаас болж зарим нь өөрийгөө хянах, аливаа үйлдлийн үр дагаврыг ойлгох чадваргүй болдог. Мөн хүүхдүүдийн бэлгийн боловсролын дутмаг байдал нь хүчирхийлэл үйлдэх шалтгаан болдог.

Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлого.

Сүүлийн таван жилийн байдлаар хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 62.7 хувь нь 18 насанд хүрээгүй хүүхэд байсан. Хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 3 хүн тутмын 2 нь хүүхэд байна. Сүүлийн 2 жилд 432 хүнийг энэ төрлийн гэмт хэрэгт гэм буруутайд тооцож ял оноосон байна. Энэ ял ногдуулсан ялтны 22.7 хувь нь 98 хүн урьд нь ял шийтгүүлж байсан хүн. Ял шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд 2021 оны 54.6 хувьд 10-15 жилийн ял, 2022 онд 52.4 хувьд 10-15 жилийн ял оногдуулсан байна. Энэ нь бага насны хүүхдийн эсрэг үйлдэж байгаа гэмт хэрэг, тэр дундаа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ногдуулах Эрүүгийн хуулийн ялын бодлогыг чангаруулах шаардлагатай гэдгийн нотолгоо болж байна. 2013-2023 оны хугацаанд бусдыг санаатай алах, бага насны хүүхдийг хүчиндэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн 3879 хүн суллагдсан байна. Үүний 45.4 хувь хүчиндэх, 13.7 хувь нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хүмүүс байна. Дээрх суллагдсан 3879 хүнээс 6 нь дахин гэмт хэрэг үйлдсэн.

Бага насны хүүхдийн эсрэг үйлдэж байгаа гэмт хэрэг, тэр дундаа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ногдуулах Эрүүгийн хуулийн ялын бодлогыг чангаруулах шаардлагатай гэдгийн нотолгоо болж байна гэж үзэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023 онд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Бүх насаар хорих ял ногдуулах”-аар заасан хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар заасан. Бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 20 жил байсныг 30 жил болгосон. Бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргүүд хөөн хэлэлцэх хугацаагүй болсон билээ. Үүний зэрэгцээ, бага насны хүүхдийг хүчиндэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй, энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас өмнө суллахгүй байхаар заасан.

Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулиар шүүхээс таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргүүдийг 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулан үзвэл, хүчиндэх гэмт хэргийг нэг удаагийн үйлдлээр үйлдсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 4.7 жилээр багассан, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндсэн хүнд оногдуулсан хорих ялын бодлого 1.5 жилээр чангарсан, удаа дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан

хорих ялын бодлого 3.7 жилээр суларч, бүх насаар хорих ял оногдуулаагүй, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулсан хорих ялын бодлого 4.4 жилээр тус тус чангарсан байна. Нийт оногдуулсан ялыг харьцуулан авч үзвэл, хорих ялын бодлого 0.7 жилээр чангарсан бөгөөд бүх насаар хорих ялыг хараахан хэрэглээгүй байна. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг 2002 оны Эрүүгийн хуульд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт тооцож байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд энэхүү үйлдлийг хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжид хуульчилснаар хүчиндэх гэмт хэргийн улсын хэмжээний статистик тоо нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын бодлого 6.3 жилээр чангарч (форум, 2020).

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан “Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” гэмт хэрэгт зөвхөн хорих ял оноохоор хуульчилсан.

Монгол Улс НҮБ-ын “Хүүхдийн эрхийн тухай” конвенцод 1990 онд нэгдэн орж хүн төрөлхтний ирээдүйн сайн сайхан байдлыг хангах энэхүү конвенцыг хангах үүрэг хүлээсэн дэлхийн 5 дахь орон болсон юм. Хүүхдийн эрхийн асуудал бол хүний эрхийн салшгүй хэсэг мөн. Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандарт /Бээжингийн дүрэм/ 1985 оны 11 сарын 29-ний Ерөнхий Ассамблейн 40/33 тоот тогтоолоор батлав. НҮБ-ын зургаадугаар чуулганаас гаргасан наймдугаар тогтоолын дагуу 17.1 дүгээр зүйлийн /б/ заалт залуу хүмүүсийн онцлог эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс хорихоос бусад арга хэмжээг аль болох их сонгон хэрэглэхийг дэмжиж байгаа юм. Иймээс нийгмийн аюулгүй байдлыг хангах эрэлт хэрэгцээг харгалзан сонгох өөр төрлийн байгаа арга хэмжээнүүдийг бүрэн ашиглах, шинэ төрлийн сонгох арга хэмжээ боловсруулах нь зүйтэй.

Энэ журмын 17.1-ийн /с/ зүйл нь нийгмийн аюулгүй байдлыг хангах холбогдох өөр арга хэмжээ байхгүй тохиолдлоос бусад үед насанд хүрээгүй хүнийг шоронд хорихоос зайлсхийхэд чиглэгдсэн зургаадугаар Конгрессын 4 дүгээр тогтоолын удирдамж болгосон зарчмын нэгтэй нийцэж байгаа юм. Үүнд:

Нөлөөллийн олон янзын арга хэмжээ:

18.1. Эрх мэдэл бүхий эрх хэмжээтэй байгууллагаас авах арга хэмжээний төрөл олон янз байх нь хорихоос аль болох зайлсхийх боломжийг бүрдүүлэх юм. Зарим нэгийг нь давхардуулан хэрэглэж болох тийм арга хэмжээ байж болно.

- Асран хамгаалах, удирдан чиглүүлэх, хяналтад өгөх;
- Ял тэнсэх;
- Нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх;
- Мөнгөн шийтгэл, нөхөн төлбөр, хохирлыг барагдуулах;
- Завсрын болон бусад арга хэмжээ авахаар тогтоох;
- Бүлэг хэсэгт нь сэтгэцийн эмчийн зөвлөгөө өгөх болон түүнтэй төстэй бусад үйл ажиллагаанд татан оролцуулах;
- Хүмүүжүүлэх болон оршин амьдрах газрыг шилжүүлэх, хүмүүжлийн бусад арга хэмжээ тогтоох гэх мэт арга хэмжээг хэрэглэх шаардлагатай гэж үзэж байна.

НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц болон дүрэм журмуудад нийгэм нь аливаа гэмт үйлдлийн эсрэг хамгаалагдсан байх ёстой ба хүүхэд хийсэн хэргийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой бөгөөд гэмт хэрэгт хамгаалах арга хэмжээ авах ёстой талаар тодорхой тусгаж.

Энэ нь насанд хүрээгүй этгээдэд хөндлөнгийн оролцоо, ялангуяа хийсэн үйлдэлд нь тохирсон арга хэмжээ авах бус харин засрал хүмүүжил олгох, нийгэмд эргэн орох нөхцөлийг нь бүрдүүлэхэд ач холбогдол өгч байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор дэлхийн улс орнууд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд тусгайлан жичид нь тогтоосон хуулийн хүрээнд ял хариуцлагыг тодорхойлж, тэдний хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангах үүднээс эрүүгийн хариуцлагыг өвөрмөц төрлүүдийг хэрэглэдэг байна (Д.Бадам, 2012).

Дүгнэлт

Монгол Улсын хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзэхэд, хүүхдийн эрхийг хамгаалах, тэр дундаа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байх хэдий ч эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хүүхэд хамгааллын чиглэлээр төрөөс баримтлах бодлогыг оновчтой тодорхойлох, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах шаардлага байсаар байна.

Монгол Улс хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр баталсан цөөнгүй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд тэдгээрийн хэм хэмжээ, үзэл баримтлал, зарчмыг үндэсний хууль тогтоомжид нэг мөр тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн гэмт хэрэг нь тодорхой объектив болон субъектив хүчин зүйлийн улмаас үйлдэгддэг бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг нь илүү “нуугдмал шинжтэй” болж, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн гаралт, хохирогчийн тоо эрс нэмэгдэх чиг хандлагатай болжээ.

Гэр бүлийн (ахуйн) хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх томоохон шалтгаан болж байна.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөр, гэмт хэргийн улмаас учирсан эд материалын болон сэтгэл зүйд учирсан гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтыг судалж, нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Гэрлэлт түүний үр дагавар эцэг, эхийн үүрэг хариуцлага, үр хүүхдэдээ үлгэр дуурайлал үзүүлэх, сурган хүмүүжүүлэх, гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Санал

Хууль эрх зүйн орчинд анхаарах асуудал.

Ялын бодлогыг чангатгах: Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах

Шүүх болон хууль хяналтын байгууллагын мэргэшсэн байдал: Хүүхэд хохирсон гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг чанар, үр дүнтэй явуулахын тулд хүүхдийн эрхийг хамгаалсан мэргэшсэн мөрдөгч, прокурор, шүүгч, хуульчдыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Боловсролын салбарт анхаарах асуудал.

Бэлгийн боловсролыг нэмэгдүүлэх: Сургуулиудад бэлгийн болон ёс суртахууны боловсролын талаар заавал сургалт оруулах нь хүүхдүүдийг эрсдэлээс сэргийлж, бие бялдар, сэтгэл зүйн хувьд зөв хандлага төлөвшүүлэхэд тусална. Хүүхдүүдэд биеэ хамгаалах, өөрийгөө хянах болон зөв хариу үйлдэл үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх нь чухал.

Эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт: Гэр бүлд бэлгийн болон ёс суртахууны асуудлыг нээлттэй ярилцдаг орчныг бүрдүүлэх талаар эцэг эхчүүдэд боловсрол олгох шаардлагатай. Хүүхдүүдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо чухал тул тэдний мэдлэгийг нэмэгдүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тустай.

Сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг.

Сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх байгууллагуудын тогтолцоог сайжруулах: Хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүдэд зориулсан тусгай сэтгэл зүйн үйлчилгээ, зөвлөгөө өгөх тогтолцоог өргөжүүлэх нь чухал. Энэ нь хохирогч хүүхэд цаашид нийгмийн харилцаанд оролцоход эерэг нөлөө үзүүлэх юм.

Эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөрүүд: Нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд хүчирхийлэлд өртөх магадлал өндөр тул тэднийг тусгай хөтөлбөрүүдээр дамжуулан хамгаалах, хөгжүүлэх шаардлагатай. Хүүхдүүдийн орчин нөхцөл, хүмүүжилд анхаарал тавьж, гэр бүл дэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийн сургалт, зөвлөгөөнүүдийг тогтмол зохион байгуулах нь үр дүнтэй.

Нийгмийн ухамсар, хандлагад өөрчлөлт оруулах.

Олон нийтийн мэдээлэл, сурталчилгаа: Хүчирхийллийн эсрэг нийгмийн ухамсрыг дээшлүүлэх, хүчирхийллийг үл тэвчих уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал. Үүний тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүчирхийллийн хор уршиг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сурталчлах кампанит ажил зохион байгуулах.

Хүчирхийллийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх: Хүүхдүүдийн хоорондын харилцааны талаар нийгэмд зөв ойлголт түгээж, хүүхдүүдийг хүчирхийллээс хамгаалах тухай нийтлэг ухамсар бий болгох нь нийгмийн хандлагыг өөрчлөхөд тусална.

Олон улсын туршлагаас суралцах.

Гадаадын туршлагаас судалж хэрэгжүүлэх: Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдэнд тохирсон нөхөн сэргээх болон боловсрол олгох талаар олон улсын туршлага, аргачлалуудыг судалж, Монголд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх нь чухал. Энэ нь манай орны онцлогт тохирсон, үр дүнтэй арга хэмжээг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

Ашигласан материал

1. “Монгол Улсын Эрүүгийн хууль”, Улаанбаатар хот, 2002 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он. №05
2. “Монгол Улсын Эрүүгийн хууль”, Улаанбаатар хот, 2015 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он. №07
3. “Монгол хэлний тайлбар толь”, Я.Цэвэл, Улаанбаатар хот, 1962 он.
4. Бат-Очир Л, Гантулга С, Энхболд Б. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг. УБ., 2011
5. С.Гантулга, Б.Энхболд. “Эрүүгийн эрх зүй: Тусгай анги” УБ, 2018 он,
6. Нээлттэй нийгэм форум “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” УБ, 2020 он,
7. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2006 он.
8. С.Жанцан, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол 90 ялын тухай сургаал*, УБ, Ангараг технологи, 2014 он,
9. С.Нарангэрэл, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж*, УБ, Соёмбо, 2019 он,
10. Бадам, Д.(2012). “Насанд хүрээгүй этгээдэд оногдуулах хорих ял, эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал”. УБ
11. “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж шинжилгээ” бодлогын судалгааны тайлан, УБ, 2019 он.
12. Sexual Assault of Young Children as Reported to Law Enforcement: Victim, Incident, and Offender Characteristics, Howard N. Snyder, Ph.D. (National Center for Juvenile Justice) 2000 он, USA.